



ХААН КОНСАЛТИНГ
АУДИТ ХХК

“ХААН КОНСАЛТИНГ АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 18 дугаар хороо, Манлайбаатар
Дамдинсүрэнгийн гудамж 14/4-р байр 3 давхарт

И-мэйл: info@khaanaudit.mn

khaanconsultingaudit@gmail.com

Шуудангийн хаяг: Төв шуудан 780

Утас: 976-70003775, /факс: 976-70114464

2026 02 25 № 02/07

Танай-ны №.....-т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРХОН СУМЫН
СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ЭНХБОЛД ТАНАА

Дархан-Уул аймгийн Орхон сумын соёлын
төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан,
гэрчилгээ хүргүүлэв.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Орхон сумын соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/59/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
/төгрөгөөр/.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	11
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	11
3.5.3 Нэмэлт төсөв.....	12
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	12
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
4.5.1 Завсрын аудитын талаар.....	13
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	14
5.1 Төлбөрийн акт.....	14
5.2 Албан шаардлага.....	14
5.3 Зөвлөмж.....	14
АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурханын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059.
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ОРХОН СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ЭНХБОЛД ТАНАА

2026.02.05 № 74

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Орхон сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант 2025 оны баталсан орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, түрээслэгчидтэй түрээсийн гэрээг байгуулаагүй, зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

4526050192

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд өвсөн судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдал бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Орхон сумын Соёлын төв нь 2025 онд 4 зорилт 48 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 91.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэгжэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	20,123,810.00	14,169,100.00
35	БАРАА МАТЕРИАЛ	20,123,810.00	14,169,100.00
351	Түүхий эд материал	1,000,000.00	1,000,000.00
35110	Тусгай зориулалттай материал	1,000,000.00	1,000,000.00
354	Хангамжийн материал	19,123,810.00	13,169,100.00
35410	Бичиг хэргийн материал	1,183,880.00	335,000.00
35420	Аж ахуйн материал	2,815,830.00	2,170,000.00
35440	Түлш, шатах тослох материал	133,300.00	366,700.00
35450	Барилгын засварын материал	3,030,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	11,960,800.00	10,297,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,044,911,620.55	987,594,650.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,044,911,620.55	987,594,650.78
392	Биет хөрөнгө	1,039,298,120.63	981,981,150.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	972,458,426.40	972,458,426.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	(66,940,795.69)	(83,148,436.09)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	200,771,867.56	213,137,419.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(88,635,742.06)	(140,735,300.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,832,405.35	42,832,405.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,807,754.93)	(36,989,127.87)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,807,231.00	4,807,231.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,636,292.00)	(2,830,242.44)
39217	Ном	12,448,775.00	12,448,775.00
393	Биет бус хөрөнгө	5,613,499.92	5,613,499.92
39301	Програм хангамж	2,954,300.00	2,954,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,162,800.08)	(2,162,800.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,822,000.00	4,822,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,065,035,430.55	1,001,763,750.78
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,065,035,430.55	1,001,763,750.78
51	Засгийн газрын хувь оролцоо	927,568,876.55	864,297,196.80
51101	Өмч: - төрийн	137,466,554.00	137,466,554.00
512	Хуримтлагдсан үр дүн	200,901,269.35	137,629,589.60
51210	Өмнөх үеийн үр дүн	245,887,364.30	200,901,269.35
51220	Тайлант үеийн үр дүн	(44,986,094.95)	(63,271,679.75)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	726,667,607.20	726,667,607.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,065,035,430.55	1,001,763,750.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	464,499,084.56	465,022,077.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,306,835.00	16,699,877.20
120	Нийтлэг татварын бус орлого	26,306,835.00	16,699,877.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,892,000.00	8,413,125.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,892,000.00	8,413,125.20
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	19,414,835.00	8,286,752.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	438,192,249.56	448,322,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	258,932,249.56	241,929,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	258,932,249.56	241,929,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	179,260,000.00	206,392,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	179,260,000.00	206,392,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	509,485,179.51	528,293,756.95

21	УРСГАЛ ЗАРДАЛ	509,485,179.51	528,293,756.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	409,383,170.89	490,100,102.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	155,393,795.55	199,698,025.39
210101	Үндсэн цалин	107,722,304.08	121,368,436.74
210102	Нэмэгдэл	37,743,507.00	64,655,667.59
210104	Урамшуулал	9,927,984.47	13,673,921.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,679,183.12	24,810,621.19
210201	Тэтгэврийн даатгал	13,624,565.77	17,024,541.25
210202	Тэтгэмжийн даатгал	1,561,750.95	1,994,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	949,284.26	997,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	708,715.52	997,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,834,866.62	3,796,379.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144,109,978.84	168,917,874.34
210301	Гэрэл, цахилгаан	3,311,919.84	3,859,854.14
210302	Түлш, халаалт	139,756,379.00	163,525,300.20
210303	Цэвэр, бохир ус	1,041,680.00	1,532,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,142,390.00	6,109,990.00
210401	Бичиг хэрэг	319,998.00	1,690,880.00
210402	Тээвэр, шатахуун	750,002.00	1,066,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	913,400.00	1,188,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	978,990.00	2,164,510.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,280,000.00	10,431,250.00
210604	Урсгал засвар	7,280,000.00	10,431,250.00
2107	Томилолт, зочны зардал	1,300,000.00	170,000.00
210702	Дотоод албан томилолт	1,300,000.00	170,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,305,220.00	3,196,220.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,944,000.00	2,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,665,000.00	-
210807	Газрын төлбөр	48,220.00	48,220.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,172,603.38	76,766,121.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900,000.00	4,083,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,272,603.38	72,682,521.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,102,008.62	38,193,654.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,496,801.00	1,595,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,774,801.00	1,154,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	722,000.00	441,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,485,186.46	7,123,328.62
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,485,186.46	7,123,328.62
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,120,021.16	29,474,725.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,120,021.16	29,474,725.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(44,986,094.95)	(63,271,679.75)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(44,986,094.95)	(63,271,679.75)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	438,192,249.56	448,322,200.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	438,192,249.56	448,322,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	258,932,249.56	241,929,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	258,932,249.56	241,929,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	179,260,000.00	206,392,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	179,260,000.00	206,392,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	446,518,916.05	449,655,925.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	446,518,916.05	449,655,925.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346,416,907.43	410,782,870.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	155,393,795.47	199,698,025.39
210101	Үндсэн цалин	107,722,304.00	121,368,436.74
210102	Нэмэгдэл	37,743,507.00	64,655,667.59
210104	Урамшуулал	9,927,984.47	13,673,921.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,679,183.12	24,810,621.19
210201	Тэтгэврийн даатгал	13,624,565.77	17,024,541.25
210202	Тэтгэмжийн даатгал	1,561,750.95	1,994,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	949,284.26	997,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	708,715.52	997,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,834,866.62	3,796,379.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144,109,978.84	168,917,874.34
210301	Гэрэл, цахилгаан	3,311,919.84	3,859,854.14
210302	Түлш, халаалт	139,756,379.00	163,525,300.20
210303	Цэвэр, бохир ус	1,041,680.00	1,532,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,098,730.00	3,601,130.00
210401	Бичиг хэрэг	600,000.00	879,000.00
210402	Тээвэр, шатахуун	916,300.00	1,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	913,400.00	1,188,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	489,030.00	234,130.00
2105	Нормативт зардал	500,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,030,000.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	9,030,000.00	8,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,300,000.00	170,000.00
210702	Дотоод албан томилолт	1,300,000.00	170,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,405,220.00	3,196,220.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,044,000.00	2,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,665,000.00	-
210807	Газрын төлбөр	48,220.00	48,220.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900,000.00	2,389,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900,000.00	2,389,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,102,008.62	38,873,054.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,496,801.00	2,275,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,774,801.00	1,154,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	722,000.00	1,121,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,485,186.46	7,123,328.62
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,485,186.46	7,123,328.62
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,120,021.16	29,474,725.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,120,021.16	29,474,725.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(1,434,666.57)</u>	<u>7,078,800.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,088,700.00	7,078,800.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,088,700.00	7,078,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,088,700.00	7,078,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,088,700.00	7,078,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(13,088,700.00)	(7,078,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(14,523,366.57)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,523,366.57	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	137,466,554.00	726,667,607.20	245,887,364.30	1,110,021,525.50
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137,466,554.00	726,667,607.20	245,887,364.30	1,110,021,525.50
Тайлант үеийн үр дүн	-	-	(44,986,094.95)	(44,986,094.95)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,466,554.00	726,667,607.20	200,901,269.35	1,065,035,430.55
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	137,466,554.00	726,667,607.20	200,901,269.35	1,065,035,430.55
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137,466,554.00	726,667,607.20	200,901,269.35	1,065,035,430.55
Тайлант үеийн үр дүн	-	-	(63,271,679.75)	(63,271,679.75)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,466,554.00	726,667,607.20	137,629,589.60	1,001,763,750.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл			-
12	Татварын бус орлого	250,479,700.00	250,342,725.20	136,974.80
12000	Нийтлэг татварын бус орлого	9,800,000.00	8,413,125.20	1,386,874.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	9,800,000.00	8,413,125.20	1,386,874.80
12200	Тусламжийн орлого	240,679,700.00	241,929,600.00	(1,249,900.00)
122005	Төсвөөс санхүүжих	240,679,700.00	241,929,600.00	(1,249,900.00)
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	250,479,700.00	243,219,396.58	7,260,303.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	250,479,700.00	243,219,396.58	7,260,303.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	247,825,100.00	240,943,796.58	6,881,303.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,512,900.00	199,698,025.39	814,874.61

210101	Үндсэн цалин	120,136,600.00	121,368,436.74	(1,231,836.74)
210102	Нэмэгдэл	66,448,200.00	64,655,667.59	1,792,532.41
210104	Урамшуулал	13,928,100.00	13,673,921.06	254,178.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,064,100.00	24,810,621.19	253,478.81
210201	Тэтгэврийн даатгал	17,084,700.00	17,024,541.25	60,158.75
210202	Тэтгэмжийн даатгал	1,994,900.00	1,994,900.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	997,400.00	997,400.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	997,400.00	997,400.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	3,989,700.00	3,796,379.94	193,320.06
2104	Хангамж, бараа материалын зардал	4,110,200.00	3,601,130.00	509,070.00
210401	Бичиг хэрэг	1,660,000.00	879,000.00	781,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,300,000.00	1,300,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	1,188,000.00	(288,000.00)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,200.00	234,130.00	16,070.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,078,800.00	4,078,800.00	1,000,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	5,078,800.00	4,078,800.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,750,000.00	170,000.00	1,580,000.00
210702	Дотоод албан томилолт	1,750,000.00	170,000.00	1,580,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	8,000,000.00	6,196,220.00	1,803,780.00
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	6,750,000.00	5,500,000.00	1,250,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,150,000.00	648,000.00	502,000.00
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	48,220.00	51,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,309,100.00	2,389,000.00	920,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,309,100.00	2,389,000.00	920,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,654,600.00	2,275,600.00	379,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,154,600.00	1,154,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,121,000.00	379,000.00
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
71702	Соёл урлаг	206,392,600.00	176,917,874.34	-
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	-	-	-
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	206,392,600.00	176,917,874.34	-
12	Татварын бус орлого	206,392,600.00	176,917,874.34	
12200	Тусламжийн орлого	206,392,600.00	176,917,874.34	

122005	Төсвөөс санхүүжих	206,392,600.00	176,917,874.34	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	206,392,600.00	176,917,874.34	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	206,392,600.00	176,917,874.34	29,474,725.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	206,392,600.00	176,917,874.34	29,474,725.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	198,392,600.00	168,917,874.34	29,474,725.66
210301	Гэрэл, цахилгаан	4,547,100.00	3,859,854.14	687,245.86
210302	Түлш, халаалт	191,698,200.00	163,525,300.20	28,172,899.80
210303	Цэвэр, бохир ус	2,147,300.00	1,532,720.00	614,580.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	8,000,000.00	
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Орхон сумын соёлын төвийн эрхэм зорилго нь үндэсний соёлын үнэт зүйлсийг бүтээн туурвих, эзэмших, түгээн дэлгэрүүлэх, уламжлуулан баяжуулж, хөгжүүлэхэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон холбогдох дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон сумын соёлын төв нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ТЕГ-ын даргын 2020 оны А/156 дугаар тушаалаар баталж, мөн оны 11 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Орхон сумын соёлын төв нь 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэлдэхүүнээр, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63,271.6 мянган төгрөгөөр буюу 6.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	20,123.8	14,169.1	5,954.7
Үндсэн хөрөнгө	1,044,911.6	987,594.6	57,317.0
Нийт хөрөнгө	1,065,035.4	1,001,763.7	63,271.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,065,035.4	1,001,763.7	63,271.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,065,035.2	1,001,763.7	63,271.6

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлт гарчээ. Үүнд:

Бараа материал дансны үлдэгдэл нь 14,169.1 мянган төгрөг болж 5,954.7 мянган төгрөгөөр буурсан нь барилгын засварын материал ангилал дахь бараа материалыг зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 987,594.6 мянган төгрөг болж өмнөх оноос 57,317.0 мянган төгрөгөөр буурсан нь Соёлын газраас 15,600.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж хандиваар хүлээн авч, тайлант хугацааны хөрөнгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,001,763.7 мянган төгрөг болж өмнөх оноос 63,271.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 241,929.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 206,392.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 241,929.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 206,392.6 мянган төгрөг, нийт

633,790.1 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 241,929.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 206,392.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарлагын гүйцэтгэл 422,134.5 мянган төгрөг буюу 92.3 хувьтай зарцуулж, орон нутгийн төсвөөс зарцуулаагүй үлдсэн 29,474.7 мянган төгрөг, улсын төсвөөс зарцуулаагүй үлдсэн 7,123.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
71702	Соёл урлаг	456,872.3	422,134.5	34,737.7	92.3
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	229,232.6	226,606.4	2,626.1	98.8
80111	Төрийн өмчийн тогтмол зардал	206,392.6	176,917.8	29,474.7	85.7
80214	Уран бүтээл хийлгэх зардал	3,750.0	2,500.0	1,250.0	66.6
81855	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	7,697.1	7,697.1	-	100.0
83603	Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан	9,800.0	8,413.1	1,386.8	85.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус байгууллага нь хоол, унааны хөнгөлөлт олгодоггүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа төлөвлөгдсөн хөрөнгө, бараа ажил үйлчилгээ байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Дархан-Уул аймгийн Орхон сумын соёлын төв, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг

хураангуйлан толилуулав. Мөн орлогын төвлөрүүлэлт болон анхан шатны баримтын бүрдэлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн аудитор Ч.Баярсайхан, аудиторын туслах Э.Тунгалагтамир нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хаан консалтинг аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Ганцэцэг, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Орхон сумын соёлын төв нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 266,261.9 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 5,325.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд улсын төсвөөс зарцуулаагүй үлдэгдэл 9.6 мянган төгрөг төвлөрүүлсэн нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар тэвчиж болох зардлыг хэмнэх ажлын хүрээнд төсвийн байгууллагуудын санхүүжилт, зарцуулалтын эрхийг хязгаарлаж, гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын ангилал буруу бүртгэсэнтэй холбоотой зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх¹ зөвлөмжийн

хэрэгжилтийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тулган шалгахад 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	1	-	1	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,066.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Тайлант онд хүндэтгэл үзүүлэх тушаал гарган албан хаагчдын хүүхдүүдэд төсвийн хөрөнгөөр 680,000.00 төгрөгийн бэлэг худалдан авч, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Орлогын төвлөрүүлэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Дээд шатны байгууллагаас баталсан төсөвтэй хамт тайлант жилийн орлогын төлөвлөгөө батлагддаг бөгөөд тухайн жил 9,800,000.00 төгрөгөөр төлөвлөгдсөн боловч гүйцэтгэлээр 8,413,125.00 төгрөгийн орлого олж, 1,386,876.00 төгрөг буюу 14.0 хувиар биелэгдээгүй ба спорт заалны түрээсийн гэрээ, Жимобайл ХХК-тай антени суурилуулсан түрээсийн гэрээнүүд байхгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.7 дахь заалтыг баримталж, орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах

Дээрх тайлангийн 5.2 дахь хэсэгт дурдсан албан шаардлага, 5.3 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу ирүүлэх, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Тайл бар
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Тайлант онд хүндэтгэл үзүүлэх тушаал гарган албан хаагчдын хүүхдүүдэд төсвийн хөрөнгөөр 680 000.00 төгрөгийн бэлэг худалдан авч, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан	1	680.0			1	680.0	-	-	-	-	
Дээд шатны байгууллагаас баталсан орлогын төлөвлөгөөг бүрэн төвлөрүүлээгүй	1	1,386.8					1	1,386.8	-	-	
Дүн	2	2,066.8			1	680.0	1	1,386.8	-	-	-

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.